



ХАН-УУЛ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 03 сарын 14 өдөр

Дугаар 5/12

Улаанбаатар хот

Д.Ганбадрахыг албан тушаалд томилох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.2, Хан-Уул дүүргийн Зам засвар, арчлалт орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дүрмийн 2.5 дахь заалт, Авлигатай тэмцэх газрын 2025 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 05/4893 дугаартай албан бичгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дөшийн Ганбадрахыг Хан-Уул дүүргийн Зам засвар, арчлалт орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын захирлаар 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдрөөс томилсугай.

2. Д.Ганбадрахын ажил хүлээлцэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	Ц.Эрдэнэбаатар	Дүүргийн менежер
Гишүүд:	О.Мөнгөншагай	Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн
	Г.Одонгоо	Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн
	М.Ариунжаргал	Дүүргийн архивч
Нарийн бичиг:	Г.Однаран	Төрийн албан хаагчийн ёс зүй, сургалт хариуцсан мэргэжилтэн

3. Д.Ганбадрахын үүрэгт ажлыг 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдөрт багтаан хүлээлцэхийг ажлын хэсэг (Ц.Эрдэнэбаатар)-т, албан тушаалын нэг сарын үндсэн цалинг Зам засвар, арчлалт орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын Төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан хэмжээгээр тооцож сар бүр олгохыг Зам засвар, арчлалт орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын нягтлан бодогч Д.Нямлхагвад тус тус даалгасугай.

4. Энэ захирамж гарсантай холбогдуулан Хан-Уул дүүргийн Засаг даргын 2024 оны Б/66 дугаартай захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ЦЭРЭН

1725010321